

СУРГУУЛИЙН ЭЦЭГ ЭХ, БАГШИЙН ХОЛБООНЫ ДАВУУ ТАЛ

Үзүүлэлт	Одоо байгаа Эцэг эхийн зөвлөл	Шинээр байгуулагдах Сургуулийн эцэг эх, багшийн холбоо (СЭЭБХ)
<p style="text-align: center;">Үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> • Ихэвчлэн ангийн түвшинд эцэг эхийн хурал хийдэг; • Сургууль, анги засварын болон бусад төрлийн мөнгө, хандив хураах; • Ангийн мэдээллийн самбар, булан хийж өгөх; • Эцэг эхийн зөвлөлөөс сургууль дээр зарим нэг уралдаан тэмцээн зохион байгуулдаг; • Эцэг эхийн зөвлөл нь нэг л сургууль дээр сургуулийн түвшинд тус тусдаа ажиллаж байна. 	<ul style="list-style-type: none"> • Сургууль дээр жил бүр “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-аар хамтарсан багийн үнэлгээ хийнэ; • Сургуулийн төсөв, худалдан авалтын талаар ойлгох ажиглалт хийнэ; • Үнэлгээ, ажиглалтын үр дүнд зөвлөмж боловсруулж, асуудлуудыг сургуулийн захирал, багш нартай хамтран сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлнэ; • Шаардлагатай бол зарим үнэлгээ, судалгааны аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх; • Бүсийн сургуулиуд үйл ажиллагааны мэдээлэл, сайн туршлагаа хуваалцах (уулзалт зохион байгуулах болон цахим хуудсаар); • СЭЭБХ-ны гишүүд, эцэг эхчүүдийг чадавхижуулах; • Сургуульд хүрэлцээгүй байгаа төсөвт дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэлгээний үр дүнд тулгуурлан орон нутгийн засаг захиргаанд хандаж төсөл бичиж асуудлыг шийдүүлэх; • Гишүүнчлэлээ нэмэгдүүлэх; • Эцэг эх, багш нэгдэж хүүхдийнхээ төлөө ажиллах; • Сургуулийн үйл ажиллагаа, боловсролын бодлого, шинэчлэлийн талаар байнгын мэдээлэл өгч ажиллах; • Багш нарын эрх ашгийг хамгаална; • Сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүдийн ашиг сонирхлыг холбосон гүүр болж ажиллана. Харин мэргэжлийн асуудал (сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулга зэрэг)-д хөндлөнгөөс оролцохгүй; • Үйл ажиллагаагаа хичээлийн жилийн эцэст сургуулийн нийт хамт олонд тайлагнаж, ирэх хичээлийн жилд хийх ажлын саналыг авч байх • Төслийн хүрээнд байгуулагдсан холбоод нь загвар СЭЭБХ болно; • Үндэсний ЭЭБХ байгуулагдаж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана;
<p style="text-align: center;">Зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> • Ангийн багшийн санаачилгаар Эцэг эхийн зөвлөлийн дарга, гишүүд сонгогддог. • Захирал өөрийн таньж мэддэг эцэг эхээ сонгодог. • Орон нутагт захирлууд хамаатнаа сонгодог. 	<ul style="list-style-type: none"> • ЭЭБХ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, ашгийн бус, өөрийгөө удирдах зохион байгуулалттай ТББ байна. • ЭЭБХ хүрээгээ тэлж зохион байгуулалтын үр өгөөжөө сайжруулна. Үндэсний түвшинд ажиллах ЭЭБХ-ны Хууль зүй, бодлогын хороо, Аудитын хороо, Гишүүнчлэлийн хороо гэх мэт байнгын хороодыг зохион байгуулж ажиллана. • Боловсролын салбарын бодлогод нөлөөлөх түвшинд үр дүнтэй оролцох чадавхитай болж, сум, аймаг, үндэсний хэмжээнд сүлжээ болж өргөжинө.

<p>Тогтвортой байдал</p>	<ul style="list-style-type: none"> • Өмнөх нийгмийн үеэс уламжлал болон хэлбэр төдий оршин тогтнож байгаа. 	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх нь дангаараа бус багш нартай хамтран ажиллавал илүү үр дүнтэй, тогтвортой ажилладаг нь олон улсын туршлагаас харагддаг. • Сургууль болон орон нутгийн холбогдох төрийн байгууллагуудтай төлөвлөгөөтэй хамтран ажиллах зорилготой. • ЭЭБХ-дыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх үйл ажиллагаа явуулахыг Төслийн зүгээс урамшуулан, цаашид сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
<p>Санхүүжилт</p>	<ul style="list-style-type: none"> • Шаардлагатай үед мөнгө хурааж тэр зүйлдээ зарцуулаад дуусдаг. 	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгохыг зорино; • Санхүүгийн бүх ажил, гүйлгээг хийх данс нээж ашиглах; • Гишүүнчлэлийн татвар жилд нэг удаа авах (төслийн хугацаанд татвар авах үгүйг болон хэзээнээс авах талаар ярилцаж байгаа); • Эцэг эх, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын (хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн) хандив; • Бусад ТББ-уудтай хамтран ажиллах; • Хуулиар хориглоогүй бусад орлого; • Дотоод болон гадаад аудитаар санхүүгийн тайлангаа баталгаажуулна. • Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан бүрэн байх;

Дүгнэлт:

- ЭЭБХ нь Монгол улсын Боловсролын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн дагуу байгуулагдана.
- ЭЭБХ нь олон улсын адил төстэй байгууллагуудын сайн туршлагыг нэвтрүүлэхийн зэрэгцээ Монголын ард түмний өвөрмөц онцлогт тохируулан үйл ажиллагаа явуулна.
Сургуулийн түвшинд эцэг эх, багш, ажилтнуудын чадавхийг бэхжүүлж, тэдний оролцоог хангаж ажиллана.
- Боловсролын чанар, орчныг сайжруулахад орон нутгийн албан хаагчидтай хамтран ажиллахад анхаарна.
- Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх загвар ЭЭБХ бий болно.